

ЭХ ӨГҮҮЛЭЛ

**ХОЙД МОНГОЛЫН ХЭСЭГТ ОРШИХ ЭРДЭНЭТИЙН ОВОО CU-МО-НЫ ПОРФИРИЙН ОРДЫН CU БА S-ИЙН ИЗОТОПЫН ШИНЖ: ТҮҮНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ, ХАЙГУУЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Yeongmin Kim<sup>a</sup>, Insung Lee<sup>a,\*</sup> | С.Оюунгэрэл<sup>a,б</sup> | Л.Жаргал<sup>б</sup> | Ц.Цэдэнбал<sup>в</sup>

<sup>a</sup> Сөүлийн Үндэсний Их Сургууль, Дэлхий ба Байгаль Орчны Шинжлэх Ухааны Сургууль, Сөүл 08826, БНСУ

<sup>б</sup> Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Улаанбаатар 14201, Монгол улс

<sup>в</sup> Эрдэнэт үйлдвэр, Орхон аймаг, 61027, Монгол улс

	Хураангуй
<b>Хүлээн авсан:</b> 2018.07.25	<p>Монголын хойд хэсэгт орших Эрдэнэтийн Овоо Cu-Мо порфирийн ордын хүдрийн эрдсүүдийн зэс (<math>\delta^{65}\text{Cu}</math>) ба хүхрийн (<math>\delta^{34}\text{S}</math>) изотопын найрлагыг хэмжив. Cu (I) сульфидийн эрдсүүдийн <math>\delta^{65}\text{Cu}</math> утга нь 0.14 ‰-ээс 2.69 ‰ хооронд хэлбэлзэж байгаа нь Cu нь зонхилох байдлаар магмын эх үүсвэрээс гаралтай гэсэн бол Cu (II) эрдсүүд болох хризосола, малахит, азурит зэрэг нь -1.01‰-ээс 10.0‰ хүртэл <math>\delta^{65}\text{Cu}</math>-ийн утгуудын хооронд их хэлбэлзэлтэй байв. Анхдагч ба хоёрдогч Cu-ийн сульфидийн эрдсүүдийн хоорондох ялимгүй ялгаа нь Cu изотопын фракцлах процессын шинжийг илтгэдэг бөгөөд үүнийг их хэмжээний зөөвөрлөлт ба/эсвэл биогенийн үйл ажиллагааны оролцоотой холбон тайлбарлаж болно. Анхдагч халькопиритийн <math>\delta^{65}\text{Cu}</math>-ийн утга нь эх үүсвэрийн өөр өөр шинж чанартай байдал ба/эсвэл өндөр температурын нөхцөлд изотопын фракцжилтын хуримтлалыг бий болгодог. <math>\Delta_{\text{Cu(II) эрдэс} - \text{Cu(I) эрдэс}}</math>-ийн эерэг утга нь тухайн ордод Cu-г бага хэмжээгээр зөөвөрлөх, массын үлдэгдэл, ба хурдан исэлдэн ангижрах урвалыг илэрхийлж байгаа юм. 0‰ рүү дөхсөн бөөгнөрөл нь хүхэр ихэвчлэн нэгэн төрлийн магмын эх үүсвэрээс гаралтай болохыг харуулж байна.</p> <p>Анхдагч сульфидийн эрдсүүдийн (пирит, молибденит ба халькопирит) <math>\delta^{34}\text{S}</math> утга 0 ‰ орчимд бөөгнөрсөн байгаа нь ихэвчлэн нэгэн төрлийн магмын эх үүсвэрээс гаралтай хүхэр болохыг харуулж байна. Үүний эсрэгээр хоёрдогч Cu-ийн сульфидийн эрдсийн <math>\delta^{34}\text{S}</math> утга -3.2 ‰-ээс 0.3 ‰ хооронд хэлбэлзэж, дунджаар -1.6 ‰ байна. Бага <math>\delta^{34}\text{S}</math>-ийн утгууд нь S изотопыг фракцлах процесс эсвэл тэдгээрийн үүсэх үеийн изотопын найрлага бүхий хүхрийн оролцооны аль нэгээр тодорхойлогддог.</p> <p>Эдгээр хүдрийн эрдсүүдэд хэмжсэн <math>\delta^{65}\text{Cu}</math> ба <math>\delta^{34}\text{S}</math> утгууд нь Cu нь ойр орчмын зэргэлдээ газрууд руу их хэмжээгээр зөөвөрлөгдөж байгааг нь Эрдэнэтийн Овоо ордын бүсэд далд Cu-ийн илрэл байх магадлал багатай байгааг харуулж байна.</p>
<b>Засварлагдсан:</b> 2018.10.18	
<b>Зөвшөөрөгдсөн:</b> 2018.11.23	
<b>Түлхүүр үг:</b> Эрдэнэтийн Овоо орд, Cu-ийн изотоп, S-ийн изотоп, Порфирын Cu-Мо-ны орд, Монгол	
<b>Харилцах зохиогч:</b> Insung Lee Дэлхий болон хүрээлэн буй орчин судлалын сургууль, Сөүлийн үндэсний их сургууль, Сөүл 151-747, Өмнөд Солонгос Имэйл: insung@snu.ac.kr	

Ишлэлийг Yeongmin, K., et al., 2019. "Cu and S isotopic signatures of the Erdenetiin Ovoo porphyry Cu-Mo deposit, northern Mongolia: Implications for their origin and mineral exploration", *Ore Geology Reviews*, 104, 656–669. <https://doi.org/10.1016/j.oregeorev.2018.11.025> хийнэ үү.

## ОРШИЛ

Шилжилтийн метал болох зэс нь  $^{63}\text{Cu}$  (69.15%) болон  $^{65}\text{Cu}$  (30.85%) гэсэн хоёр тогтвортой изотоптой (de Laeter et al., 2003). Cu нь байгалийн систем дэх биологийн ба биологийн бус механизмын аль алинд өргөн хэрэглэгддэг (e.g., Beard et al., 2004; Styrup et al., 2008; Weiss et al., 2008), гэхдээ Cu-ийн изотопын найрлагын хэмжилтийн өмнөх ажлуудад шинжилгээний алдаа нь иончлолын өндөр энергиэс шалтгаалан Дулаан Ионжилтийн Масс Спектрометрээр (Thermal Ionization Mass Spectrometry TIMS) хэмжихэд 1.5 % хүрч байсан (Walker et al., 1958; Shields et al., 1965). Уг шинжилгээний муу нарийвчлал нь Cu-ийн изотопын шинжилгээг олон арван жилийн турш олон судалгааны ажилд хэрэглэхийг хязгаарласан болно. Гэсэн хэдий ч шинжилгээний багаж хэрэгслийг сайжруулснаар Cu-ийн изотопыг 0.2‰-ээс илүү нарийвчлалтай Олон Цуглуулагчтай Индукцийн Хос Плазмт Масс Спектрометрээр (Multi Collector-Induced Coupled Plasma-Mass Spectrometry MC-ICP-MS) хэмжих боломжтой болсон (Marichal et al., 1999; Zhu et al., 2000). Хүдэр үүсгэгч орчин дахь Cu-ийн изотопын найрлага нь түүний эх үүсвэр, уусмалын хөдөлгөөнийг шууд нотлох баталгаа болох тул Cu-ийн хүдрийн ордуудын гарал үүсэл ба Cu-ийн изотопын фракцжилтын явцыг ойлгохын тулд өөр өөр төрлийн хүдрийн ордын Cu агуулсан эрдсүүдийн Cu-ийн изотопын харьцааг харьцуулан ( $^{65}\text{Cu}/^{63}\text{Cu}$ ) судлах нь нэмэгдсээр байна (Larson et al., 2003; Ehrlich et al., 2004; Graham et al., 2004; Rouxel et al., 2004; Mathur et al., 2005, 2009; Markl

et al., 2006; Asael et al., 2007; Maher and Larson, 2007; Wall et al., 2007; Li et al., 2010; Berkenbosch et al., 2015; Ripley et al., 2015; Duan et al., 2016; Wang et al., 2017; Wu et al., 2017a,b; Luczaj and Huang, 2018). Ялангуяа Cu порфирийн ордууд нь Cu-ийн ордын бусад төрлүүдтэй харьцуулбал  $^{65}\text{Cu}/^{63}\text{Cu}$ -ийн харьцааг харьцангуй их хэмжээгээр харуулдаг бөгөөд энэ нь гол төлөв бага температуртай орчинд исэлдэн ангижрах урвал явагдахад Cu-ийн изотопын фракцжилтийн харьцаа харьцангуй их байдаг тул тухайн ордын гарал үүсэл ба хүдэр үүсгэгч орчны талаар үнэлж барашгүй мэдээллийг өгдөг (Larson et al., 2003; Graham et al., 2004; Mathur et al., 2009; Li et al., 2010; Palacios et al., 2011; Wu et al., 2017b). Cu-ийн хүдрийн эрдсүүдийн доторх Cu-ийн изотопын найрлагын ялгаралт нь Cu-ийн хүдрийн эрдсүүдийн төрлүүдийг (анхдагч ба хоёрдогч) тодорхойлоход хэрэгтэй үзүүлэлт байж болох юм (Mathur et al., 2012, 2013, 2018; Duan et al., 2016; Wu et al., 2017b). Саяхан Mathur нар (2018) Cu-ийн изотопын найрлагад үндэслэж хийсэн халькозины ангилал нь эрдэсжилтийн загварыг сайжруулахад тустай гэж нотолсон. Цаашилбал, Cu (I) ба Cu (II) эрдсүүдийн хослолуудын хоорондох Cu-ийн изотопын зөрүүг ордын хэмжээнд Cu-ийн зөөвөрлөлтийн чухлыг үнэлж, илрээгүй Cu-ийн илрэлийг судлахад ашиглаж болно гэсэн хэд хэдэн судалгааг санал болгов (Markl et al., 2006; Asael et al., 2007; Mathur et al., 2009). Хүдрийн ордууд дахь сульфидийн эрдсүүдийн хүхрийн (S) изотопын найрлага ( $^{34}\text{S}/^{32}\text{S}$ ) нь хүхрийн эх үүсвэрийг хязгаарлах, гидротермаль уусмалд агуулагдах хүхрийн зүйлийн

хувьсал өөрчлөлтийг үнэлэхэд ашиглаж ирсэн (Ohmoto, 1972, 1979; Taylor, 1987; Seal et al., 2000; Seal, 2006). Си-ийн порфирийн систем дэх сульфидийн эрдсийн  $^{34}\text{S}/^{32}\text{S}$  харьцаа нь мантийн гаралтай хүхрийн эх үүсвэрийн шинжийг харуулдаг (жишээлбэл, Taylor, 1987; Seal, 2006; Wilson et al., 20007 ба тэдгээрт дурдсан жагсаалт), харин исэлдсэн ба ангижирсан зүйлийн хооронд изотопын фракцжилтаас болж исэлдсэн хүхрийн ихсэлт гидротермаль уусмал дахь зүйлүүд  $^{34}\text{S}/^{32}\text{S}$ -ийн харьцааг бууруулдаг (Rye, 1993; Seal et al., 2000; Rye, 2005; Seal, 2006). Жишээлбэл, Хашгэрэл нар (2006) Оюу толгойн Си порфирийн систем дэх сульфидийн эрдсүүдийн  $^{34}\text{S}/^{32}\text{S}$  харьцаа бага байгаа нь гидротермаль уусмалын исэлдэлтийн нөхцөлтэй хамааруулж үзсэн.

Монголын хамгийн том Си-Мо-ны порфир ордуудын нэг болох Эрдэнэтийн Овоо орд нь Монголын хойд хэсэгт Орхон аймгийн төв хэсэгт байрлах Эрдэнэт хотын ойролцоо, Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 384 км зайд оршдог. Энэ ордыг 1964 онд анх илрүүлж, 1978 оноос олборлож эхэлсэн (Gerel et al., 2005; Gerel and Munkhtsengel, 2005). АНУ-ын Геологийн Судалгааны (USGS) тайланд дурдсанаар Эрдэнэтийн Овоо орд нь 1 780 сая тонн хүдэр агуулдаг ба 0.62% Си ба 0.015% Мо агуулгатай, 11 тонн Си ба 0.162 тонн Мо металлын нөөцтэй (Singer et al., 2008). Якубчук нар (2012) Си-ийн ордын ангиллыг санал болгосноор Эрдэнэтийн Овооны ордыг 10 сая.тонн Си-аас дээш агуулсан асар том Си-ийн орд болгон тодорхойлсон. Ордын хэмжээ, нөөц, эдийн засгийн хувьд Монголын аж үйлдвэрт ихээхэн ач холбогдол өгдөг тул геологийн

тогтоц, геохимийн шинж чанар, хүдэр үүсэх процесс, үүслийн насны талаар олон судалгааг ордыг нээж ашигласнаас хойш явуулсан (Khasin et al., 1977; Koval et al., 1982; Gavrilova et al., 1984, 1990; Sotnikov et al., 1995; Dejidmaa and Naito, 1998; Gerel, 1998; Watanabe and Stein, 2000; Gerel et al., 2005; Gerel and Munkhtsengel, 2005; Berzina and Sotnikov, 2007; Kavalieris et al., 2017). Магмын интрузив чулуулаг болон ордын хүдэржилтийн насыг тодорхойлохын тулд цацраг идэвхит изотопын хэд хэдэн шинжилгээ хийсэн, гэхдээ металын эх үүсвэр, үүслийн процессыг шууд нотлох баримт, мөн Си-ийн далд илрэлүүдийн байж болзошгүй боломжийн тухай хүдрийн ашигт малтмалын тогтвортой изотопын судалгааг цөөн хийсэн болно.

Энэхүү судалгаанд бид Эрдэнэтийн Овоо Си-Мо-ны порфир ордын хүдрийн эрдсүүдийн Си ба S изотопын өгөгдлийг илтгэхдээ: (1) хүдрийн эрдсүүдийн изотопын шинж чанараас Си ба хүхрийн эх үүсвэрийг тодорхойлох, (2) эрдэсжилтийн явц дахь изотопын фракцжилтын процессыг ойлгох, (3) Си-ийн изотопын өгөгдлөөс судалгаа хийж буй бүсэд ордын хайгуулын болон ордын орчинд үзүүлэх нөлөөллийг хэлэлцэх.

## ГЕОЛОГИЙН ТОГТОЦ


### 2.1.Региональ геологи

Төв Азийн долоон Си-ийн бүслүүрийн нэг болох Монголын дэд мужид багтсан хожуу Пермээс түрүү Триасын Орхон-Сэлэнгийн хотгор нь Сибирийн кратоны идэвхтэй захын нэг хэсэг юм (Yakubchuk et al., 2012). Энд хожуу палеозойгоос мезозой хүртэл субдукцтай холбоотой вулканоген чулуулаг тархсан ба энэ

нь Сибирийн кратон болон түрүү Кембрийн үеийн чулуулаг бүхий гурван массиваас бүрдсэн Төв Монголын массивын хооронд байрладаг (Зураг 1; Watanabe and Stein, 2000; Yakubchuk et al., 2012). Ганц том Амурын массив мезозойн үед эдгээр массивуудыг нэгтгэж, Монгол-Агнуурын далайгаар Сибирийн кратоноос тусгаарласан (Gerel and Munkhtsengel, 2005). Хожуу Палеозойгоос Мезозой хүртэл Монгол-Агнуурын далай хаагдаж, хойд зүгт Сибирийн кратоны доогуур

субдукцлэсэн (Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005; Windley et al., 2007).


Тэд энэхүү коллиз ба субдукц Монгол дахь дунд Юрийн галавын үед дууссан бөгөөд Хангай-Хэнтийн уулархаг газар, тэр дундаа Орхон-Сэлэнгийн хотгорыг дээш өргөхөд хүргэсэн гэж үзсэн. Эрдэнэтийн Овоо орд нь субдукцийн бүсээс 320 км зайд оршдог бөгөөд Хангай-Хэнтийн уулархаг газрын өмнөд хилийг эзлэн оршдог.



**Зураг 1.** Сибирийн өмнөд, Хятадын хойд болон Монголын хойд хэсэгт орших Монгол-Агнуурын атираат бүслүүрийн бүдүүвч зураг (Gerel and Munkhtsengel, 2005)

Орхон-Сэлэнгийн хотгорыг Пермээс Мезозойн эхэн үеийн вулканоген гаралтай тунамал чулуулгууд болон Зураг 2-т үзүүлсний дагуу дундаас дээд Триас ба Юрагийн настай вулканоген гаралтай чулуулгууд байна. Хануй бүлэгт хамаарах Пермийн вулканоген гаралтай чулуулаг нь Неопротерозойн хувирмал чулуулаг, Палеозойн тунамал үелсэн хурдас, Девоны гранитоидууд

ба интрузив бус чулуулгуудаас бүрдсэн суурийн чулуулгууд дээр байрладаг. (Gerel and Munkhtsengel, 2005). Хануй групп нь дээд Пермийн суурилаг болон дундлаг найрлагатай вулканоген формацаас болон доод Пермийн хүчиллэг вулканоген формац нь суурилаг вулкан болон вулканоген хэмхдэст чулуулгаар хучигдсан байна (Зураг. 2).



**Зураг 2.** Эрдэнэтийн Овоо Cu-Mo-ны порфир ордын талбайн геологийн зураг (Gerel and Munkhtsengel, 2005)


Эрдэнэтийн Овоо орд нь хожуу Пермийн Сэлэнгэ интрузив бүрдлийн гранит, габбро, диоритод агуулагдах ба Сэлэнгэ бүрдлийг гурван фазад (түрүү, гол болон сүүлийн) хуваагддаг (Gerel, 1998; Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005; Berzina and Sotnikov, 2007) (Зураг. 3). Түрүү фаз нь диоритоос монзонит хүртэл эгнээг үүсгэх ба энд габбродиорит, диорит, сиенодиорит, монзонит ба кварц монзонитууд багтана. Гол фаз нь гранитоидоос тогтох ба тухайлбал граносиенит, гранодиорит болон лейкогранит, сүүлийн фазад лейкогранит болон гранит зонхилно. Сэлэнгийн бүрдэл нь хожуу Пермээс түрүү Триасын Эрдэнэт порфир бүрдлийг түрсэн байх ба энэ нь габбродиоритоос гранодиорит, гранитаас диоритын

эгнээ болон гранодиоритоос голлон бүрддэг (Dejidmaa and Naito, 1998; Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005). Dejidmaa, Naito (1998) нар Эрдэнэт порфир бүрдлийг 3 үе шатад хуваасан байдаг: диорит порфир бүрдэл, гранодиорит порфир бүрдэл болон брекчитэй эвшил үүсгэсэн гранодиорит. Гэрэл, Мөнхцэнгэл нар (2005) мөн эрдэсжилттэй холбоотой Эрдэнэт порфир бүрдэл нь субвулкан ба тэсрэлтийн штокууд, үүнд кварц-диорит порфирит, диорит, кварц-сиенит, гранодиорит, гранит, лейкогранит орно. Сиенит порфирийн дайкууд ба трахит-трахиандезит-шүлтлэг базальтын эгнээтэй холбоотой порфирууд нь Сэлэнгийн интрузив ба Эрдэнэт порфир бүрдлүүдийг түрсэн (Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005).

## 2.2. Ордын геологи

Эрдэнэтийн овооны хүдрийн дүүрэг нь 20-25 км-ийн диаметр бүхий структур дотор, олон тооны интрузив

төвүүд болон дайкуудтай, хувирсан гранодиоритын штокуудтай, ордын хүдрийн биет нь 2x1 км-ийн талбайд оршдог (Зураг 3).



**Зураг 3.** Эрдэнэтийн Овоо орд дахь ил уурхайн геологийн зураг ба судалгааны дээжийн байршил

Эрдэнэтийн Овоо хүдрийн дүүрэгт үүссэн Cu-Mo эрдэсжилт нь кварц-диорит, гранодиорит порфир ба гранит порфирээс бүрдсэн Эрдэнэт порфир бүрдэлтэй холбоотой бөгөөд хүдэр агуулсан штокверк нь Сэлэнгийн интрузив бүрдлийн гранодиорит, гранит, кварцатсиенитийг түрсэн (Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005). Ордын эрдэсжилт нь бараг босоо ба хоолой маягийн хожуу Триасын гранодиорит порфиртэй холбоотой ба сарнисан болон судлаар хянагдсан эрдэсжилт хөгжсөн (Gerel and Munkhtsengel, 2005). Хээрийн жоншны судалтай сул потассик хувирлын бүс нь агуулагч чулуулагт тохиолддог бөгөөд судлын бөөгнөрөл болон Cu-Mo-ийн эрдэсжилтэнд чухал кварц-серицитийн хувирал дээр нь хучсан байдалтай


байна (Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005). Өргөн тархсан кварц-серицитийн хувиралд хээрийн жонш нь цагаан гялтгануураар түрэгдэж байгааг харуулна (Gerel et al., 2005). Хүдрийн эрдсүүд нь пирит, молибденит, халькопирит, халькозин, борнит нь агуулагч чулуулагт судланцар болон/ эсвэл сарнисан байдлаар агуулагддаг (Watanabe and Stein, 2000). Хүдрийн гол эрдсүүд болон хувирлуудын аль алин нь ордын дотор бүсчлэл үүсгэж сайн хөгжсөн байдаг (Gerel et al., 2005; Gerel and Munkhtsengel, 2005). Пирит нь голчлон захын хэсэгт тохиолддог, өндөр агуулгатай халькопирит-халькозин-борнитын хүдэр нь цөмдөө байдаг (Gerel and Munkhtsengel, 2005). Серицитийн (кварц-серицит), дундлаг аргиллитжих (хлорит-серицит) ба профиллит (хлорит

ба эпидот-хлорит) хувирлын бүсүүд нь ордын цөмөөс зах руугаа хөгжсөн (Gerel et al., 2005). Борнит-халькозин-ковеллины бөөгнөрөл бүхий 30-300 м зузаантай Си-ийн хоёрдогч баяжилтын бүсийн дээд талд хучсан байдлаар гиперген бүсэд цэвэр Си болон Си-ийн хүчилтөрөгчтэй нэгдлүүд болох малахит, азурит, куприт зэрэг эрдсүүд байдаг (Watanabe and Stein, 2000; Gerel and Munkhtsengel, 2005).

Эрдэнэтийн Овоо ордын эрдэсжилт, хувирлын үе шатыг хэд хэдэн судлаачид судалсан. Watanabe болон Stein (2000) нар Жаргалсайханы 1996 онд ордын эрдэсжилтийн дараалсан үе шатуудыг дараах байдлаар авч үзснийг танилцуулсан: (1) магнетит, (2) пирит-кварц, (3) молибденит-кварц, (4) халькопирит-пирит-кварц, (5) пирит, (6) пирротин-халькопирит ± кубанит, (7) халькозин-борнит (8) галенит-сфалерит-теннантит. Түүнчлэн Гэрэл болон Мөнхцэнгэл (2005) нар Эрдэнэтийн Овоо ордын хүдрийн гол эрдсүүдийн хам үүслийн дарааллыг өмнөх судалгаануудаас (Khasin et al., 1977; Gavrilova et al., 1984, 1990) нэгтгэж, эрдэсжилтийн нэгдсэн үе шатуудыг тайлбарласныг тодорхойлвол: (1) кварц-серицит, (2) кварц-халькопирит-пирит, (3) кварц-пирит-молибденит-халькопирит, (4) кварц-халькопирит-теннантит, (5) кварц-пирит-галенит-сфалерит, (6) борнит-халькозин-ковеллин, (7) гипс-кальцит-пирит. Тэд хүдрийн өмнөх эхний үе шат гэж ангилж, дараа нь хүдэржилтийн дөрвөн үе шат, нэг Си-ийн хоёрдогч баяжилтын үе шат, хүдрийн дараах сүүлийн үе шат гэж ангилсан.

Эрдсүүдийн хам гарал үүслийн дарааллыг эдгээр судалгаануудаас

ялимгүй зөрүүтэй боловч эрдэсжилтийн таван үе шатуудад дараах байдлаар хуваадаг: кварц-пирит, кварц-молибденит, (кварц)-халькопирит, кварц-сфалерит-галенит (полиметаллын), борнит-халькозин-ковеллин (хоёрдогч баяжилтын бүс) (Khasin et al., 1977; Gavrilova et al., 1984; Gerel and Munkhtsengel, 2005). Гол хүдэр ба хүдрийн бүс эрдсүүдийн хам гарал үүслийн дарааллыг Зураг 4-т үзүүлэв.



**Зураг 4.** Эрдэнэтийн Овоо ордын гол хүдэр ба хүдрийн бүс эрдсүүдийн хам гарал үүслийн дараалал (Гаврилова нар, 1984-ээс өөрчилсөн)

### 2.3. Ордын нас


Хоёр бүрдлийн насны судалгааны үр дүнг хэд хэдэн судалгаа, ялангуяа Сотников ба бусад судлаач нарын (1995) хийсэн анхдагч судалгаагаар оруулсан.

Сэлэнгийн интрузив бүрдлийн K-Ar нас нь 290-260 сая.жилийн хооронд хэлбэлздэг бөгөөд Эрдэнэт порфир бүрдлээс авсан биотитийн K-Ar насны үр дүнг ойролцоогоор 250 сая.жил ба 230 сая.жил гэж авч үзсэн (Sotnikov et al., 1995). Эдгээр үр дүн нь хоёр үе шаттай магматизм үүссэнийг илтгэнэ гэж хэмээн тэд санал болгов. Rb-Sr аргаар гаргаж авсан ижил төстэй насны үр дүнгээс харахад хоёр үе шаттай магматизм илэрч, эхний шатанд 253 ± 18 сая.жил, 252 ± 11 сая.жил, 248 ± 17 сая.жил, 223 ± 9 сая.жил ба 220 ± 7 сая.жил байна (Sotnikov et al., 1995; Berzina et al., 1999). Гэрэл ба Мөнхцэнгэл нар (2005) Эрдэнэт порфирийн бүрдлийн гранитад хийсэн K-Ar-ны аргаар хийсэн насны үр дүн 245-226 сая.жил ба 226-21 сая.жилийн хооронд хэлбэлздэг болохыг танилцуулав.  $^{40}\text{Ar}/^{39}\text{Ar}$  насны судалгаагаар плагиоклаз (225 ± 7 сая.жил Berzina et al. (1999)) ба серицит (207 ± 5 сая.жил Lamb and Cox (1998)) дээр хийсэн. Ватанабе, Стейн нар (2000) Эрдэнэтийн Овоо ордоос

240.7 ± 0.8 ба 240.4 ± 0.8 сая.жилийн настай молибденитийн насыг анхдагч эрдэсжилтийн процесст хамруулсан. Эдгээр үр дүнгүүд нь  $^{40}\text{Ar}/^{39}\text{Ar}$  наснаас хамаагүй эрт байсан гэж нотолсон нь гидротермаль үйл явцын туршид  $^{40}\text{Ar}/^{39}\text{Ar}$  насыг дахин хамааруулсантай холбоотой байж болох юм. Кавалиерис нарын хийсэн саяхны судалгаагаар (2017) гэсэн хэдий ч мусковитын  $^{40}\text{Ar}/^{39}\text{Ar}$  насны шинэ үр дүнг 239.7 ± 1.6 ба 240 ± 2.0 сая мэдээлсэн нь өмнөх Re-Os насуудтай тун ойрхон байна.

### ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эрдэнэтийн Овоо ордын ил уурхайгаас чулуулаг, хүдрийг төлөөлөх дээжүүдийг цуглуулсан ба эдгээр нь судланцар болон сарнисан янз бүрийн хүдрийн эрдсүүдийг агуулдаг (Зураг. 5А). Дээжлэлтийн ихэнх байршил нь гол эрдэсжилтийн процесстой холбоотой гранодиорит, гранодиорит порфир ба цахиуржсан диорит порфиртай эвшил үүсгэнэ (Зураг 5Б).




**Зураг 5.** (А) ба (Б) Эрдэнэтийн Овоо ордын ил уурхайн ерөнхий байдал, (В) т чулуулагт үүссэн судланцарууд ба (Г) Cu (II) эрдсийн хуримтлал



Цуглуулсан гранодиорит порфирийн дээжүүд нь кварцын судлуудтай хувирсан гранодиорит ба Эрдэнэт порфир бүрдэлтэй холбоотой хүдэр агуулсан штокверкээс бүрдэнэ (Зураг 5В). Си-ийн ислийн эрдсүүд болох малахит, азурит болон хризоколла сайн хөгжсөн байдаг (Зураг 5Г). Хээрийн жонш болох альбит нь ихэрлэлт үүсгэсэн ба кварц нь изометрлэг зөв бүс хэлбэртэй (Зураг 6-А). Хоёрдогч хувирлын улмаас плагиоклазын

полисинтетик ихэрлэлт эрчимтэй серицитжих хувирлаас шалтгаалан сайн харагддаггүй (Зураг 6Б). Плагиоклаз нь андезины найрлагатай хавтгайлаг, призмлэг хэлбэртэй, серицитэд бага зэрэг хувирсан (Зураг 6В). Хлорит нь бараан өнгөтэй эрдсүүд болох эвэрхуурмаг ба биотит хувирахад үүссэн (Зураг 6В-Д). Кварц-серицитийн хувирал нь кварц, серицит болон пиритүүдтэй ба потассик хувирлын дээд хэсгээр хучсан байдаг (Зураг 6Е).



**Зураг 6.** Эрдэнэтийн Овоо орд дахь агуулагч чулуулгуудын микробичиглэлийн зураг. (А) Альбитын тод полисинтетик ихэрлэлт ба изометрлэг бүтэцтэй кварц бүхий; (Б) плагиоклазын серицитийн хувирал; (В) хлорит, кварц ба хувирсан ортоклаз; (Г)-(Д) бараан эрдсийн хувирлаар үүссэн хлорит (Е) өргөн тархсан кварц-серицитийн хувирал. chl: хлорит, qtz: кварц, ser: серицит


Шүлтгүйжиж исэлдсэн оройн бүс аль хэдийн элэгдэж, ордын ихэнх хэсгийг эзлэх сульфидийн хоёрдогч баяжилтын

бүсэд олборлолтын явц үргэлжилж байна. Энэ бүс хөгжсөн 1325 м-ээс 1310 м, 1250 м-ээс 1235 м-ийн

түвшинүүдээс чулуулгийн дээжүүдийг цуглуулсан.

Сульфидийн эрдсүүдээс хамгийн түгээмэл пирит нь изометрлэг, хэдэн миллиметрийн хэмжээтэй ба силикат эрдсүүдтэй тухайлбал кварц, серицит болон бусад хүдрийн эрдсүүдтэй эвшил үүсгэнэ (Зураг 7А). Ордод агуулагдах гипоген Си-ийн сульфидийн эрдэс нь халькопирит бөгөөд кварц-пирит эсвэл халькозин-борнит-ковеллин дагалддаг юм (Зураг 7А–В). Борнит, ковеллин зэрэг бусад сульфидийн эрдсүүд өргөн тархсан байдаг. Гиперген баяжилтын бүс нь 300 м хүртэл зузаантай, өндөр агуулгатай бүс бөгөөд бусад

сульфидийн эрдсүүдийг хоёрдогч халькозин түрж зонхилсон байдаг. Энэ нь пирит ба халькопирит дээр ууссан байдаг (Зураг 7А–В). Борнит ба ковеллин нь пирит ба халькопиритыг хучсан байдалтай, ургалт нь халькозинтой хамт байна. Сфалерит ба галенит нь кварц-пирит-халькопирит эсвэл кварц-молибдениттэй хамт тохиолддог (Зураг 7В–Д). Өөр сульфидийн хүдрийн эрдэс болох молибденит нь Си давамгайлсан эрдэсжилтийн процессоос өмнө кварц-молибденит судлууд эсвэл кварц-пириттэй холбоотой байдаг (Зураг 7Е). Молибденит нь халькопириттэй хамт ховор тохиолддог.



**Зураг 7.** Эрдэнэтийн Овоо орд дахь хүдрийн эрдсүүдийн ойсон гэрлийн микроскопын зураг. (А) Зонхилох гипоген эрдсүүд: халькопирит, пирит; (Б) Бусад анхдагч эрдсүүдийг зонхилон түрсэн хоёрдогч эрдэс-халькозин; (В) сфалерит дагалдсан гипоген эрдсүүд; (Г)-(Д) пириттэй хамт тохиолддог сфалерит ба галенит; ба (Е) кварц-молибденит судалтай буюу кварц-пиритийн судалтай молибденит. сс: халькозин, сру: халькопирит, gn: галенит, mb: молибденит, py: пирит, qtz: кварц, sph: сфалерит

## ШИНЖИЛГЭЭНИЙ АРГУУД

Силикат ба хүдрийн эрдсүүдийг микроскопоор судлахын тулд чулуулгийн шиф болон хүдрийн аншлифийг бэлтгэсэн. Си ба S-ийн изотопын шинжилгээнд хамрагдах пирит, молибденит, Си-ийн хүдрийн эрдсүүдийг хүдэр агуулсан чулуулгийг буталсны дараа бинокуляр ашиглан түүж авсан.

### 4.1. Си-ийн изотопын шинжилгээ

Си-ийн хүдрийн дээжийг урьдчилан боловсруулж, цэвэршүүлэх бүх химийн үйл ажиллагааг БНСУ-ын Очан хотод байрладаг Солонгосын Суурь Шинжлэх Ухааны Хүрээлэн (Korea Basic Science Institute KBSI)-ийн цэвэр өрөөнд (Өрөө 100) хийсэн. Давхар нэрсэн нэрмэл ус ба азотын хүчил ( $\text{HNO}_3$ ), давсны хүчил (HCl), хайлуур хүчил (HF) зэрэг урвалжуудыг ашигласан болно.

#### 4.1.1. Си-ийн изотопыг урьдчилан боловсруулах үйл явц

Ойролцоогоор 0.1 г гар аргаар ялгасан Си-ийн хүдрийн эрдсийг тефлон шилэн аяганд хийж,  $180\text{-}200^\circ\text{C}$ -т 3:5 харьцаатай хольсон  $\text{HNO}_3$  ба HF-ийн 8 мл уусмалд хийж уусгана. Дээжийг уусгаж бүрэн дууссаны дараа тунадасажсан цахиурын тетрафторид ( $\text{SiF}_4$ )-ийг арилгахын тулд 5 мл 6Н HCl нэмсэн. Дараа нь уусмалыг хатааж, 5%  $\text{HNO}_3$ -аар шингэлж, Си-ийн бөөгнөрлийг Индуктив Хосолсон Плазм-Оптик Ялгаруулалтын Спектрометрийн (Inductively Coupled Plasma-Optical Emission Spectrometry (ICP-OES, PerkinElmer Optima 8300) багажаар шинжлэв.

#### 4.1.2. Си ялгах ион солилцооны хроматографи

Бид Маречал (1999) нараас гаргасан анион солилцооны хроматографийн аргаар Си ялгах аргачлалын дагуу явуулсан. Си-г уусмалаас ялгахын тулд анионы солилцооны давирхай (AG® MP-1 M, 100-200 торон) хроматографийн багана (Bio-rad компанийн Poly-Prep®, 0.8 Ч 4 см) ашигласан болно. Баганыг 10% HCl-аар цэвэрлэж, 2 мл (ойролцоогоор 1.2 г) анион солилцооны давирхайгаар дүүргэсэн. Давирхайг 7 мл 0.5Н  $\text{HNO}_3$ , 5 мл 7Н HCl, 2 мл нэрмэл усаар дараалан 3 удаа цэвэрлэж, давирхай доторх жижиг хэсгүүдийг зайлуулсан.. Дараа нь давирхайг 6 мл 7Н HCl + 0.001% устөрөгчийн хэт исэл ( $\text{H}_2\text{O}_2$ )-аар ангижруулсан. Давирхай дээр 0.5 мл 7Н HCl + 0.001%  $\text{H}_2\text{O}_2$  хольцоор нэмсний дараа дээжийг 0.5 мл 7Н HCl + 0.001%  $\text{H}_2\text{O}_2$ -ийн уусмалд хийж давирхай руу хийж шингээнэ. Холбогч хэсгийг 10 мл 7Н HCl + 0.001%  $\text{H}_2\text{O}_2$ -д арилгаж, дараа нь Си-ийг 24 мл 7Н HCl + 0.001%  $\text{H}_2\text{O}_2$ -тай хольсон. Багана хроматографиар ялгах ажиллагааг хүснэгт 1-д тайлбарласан болно. Ион солилцооны хроматографийн аргаар Си ялгах үр ашгийг тодорхойлохын тулд ICP олон элементийн стандарт шийдэл (AccuTrace™ лавлагааны стандарт) ба АНУ-ын хоёр Геологийн Алба (USGS) харьцангуй өндөр Си-ийн агууламж бүхий геологийн лавлах материал (BHVO-2 ба BIR-1a) -ийг туршиж үзсэн. Материалыг нөхөн сэргээх түвшин 95% -иас дээш байсан ба баганаар ялгах явц нь илрүүлэх хязгаарт байсан.

**Хүснэгт 1. Си-ийн изотопын шинжилгээний багана  
хроматографиар ялгах ажиллагаа**

Процесс	Дунд	Эзэлхүүн (мл)
Давирхайг ачаалах	AG® MP-1M, 100-200 нүх	2
Давирхайг цэвэрлэх*	0.5N HNO <sub>3</sub>	7
	7N HCl	5
	H <sub>2</sub> O	2
Ангжруулах	7N HCl + 0.001% H <sub>2</sub> O <sub>2</sub>	6
Дээж ачаалах		0.5
		0.5
Na, Mg ялгах		10
Cu ялгах		2 x 12

\* Гурван удаа давтана

**4.1.3. Си-ийн изотопын шинжилгээ**

Хүдрийн дээжүүдийн Си-ийн изотопын найрлагыг MC-ICP-MS (Neptune, Thermo Scientific) дээр Очан дахь KBSI дээр хэмжсэн. Хэмжих хэрэгслийн массын фракцийг хязгаарлах, засах зорилгоор жишиг стандарт хаалт (SSB) аргыг ашигласан болно. Хэмжсэн дээжүүдийн Си-ийн изотопын харьцааг дараах байдлаар ашиглалтын стандарт материал болгон ашигладаг олон улсын Си стандарт материал (ERM®-AE647)-тай харьцуулж тэмдэглэв.

$$\delta^{65}\text{Cu}_{(\text{ERM}^{\circ}\text{-AE647})} = \left[ \frac{({}^{65}\text{Cu}/{}^{63}\text{Cu})_{\text{дээж}}}{({}^{65}\text{Cu}/{}^{63}\text{Cu})_{(\text{ERM}^{\circ}\text{-AE647})}} \right] \times 1000$$

Урьд өмнө мэдээлэгдсэн ихэнх Си-ийн изотопын утгыг ( $\delta^{65}\text{Cu}$ ) өөр олон улсын Си-ийн стандарт материалтай харьцуулсан (NIST SRM976) ба  $\delta^{65}\text{Cu}$  (ERM®-AE647)-ээс ойролцоогоор 0.21‰-аар ялгаатай  $\delta^{65}\text{Cu}$  (SRM 976) болно (Moeller нар, 2012). Хэмжсэн  $\delta^{65}\text{Cu}$  (ERM®-AE647) утгыг дараах тэгшитгэлийг ашиглан  $\delta^{65}\text{Cu}$  (SRM 976) утга уруу тохируулав.

$$\delta^{65}\text{Cu}_{(\text{NIST SRM976})} (\text{‰}) = \delta^{65}\text{Cu}_{(\text{ERM}^{\circ}\text{-AE647})} (\text{‰}) + 0.21$$

**4.2. S-ийн изотопын шинжилгээ**

Гар аргаар сонгосон сульфидийн эрдсийг ацетон ба нэрмэл усаар цэвэрлэсэн агатан нухуур дотор нунтаглаж бэлтгэсэн. Нунтагийг 3.5x5 мм-ийн цагаан тугалган цаасан аяганд хийж, элементийн анализатор (EA) -д 1030°C температурт урвалж материалтай хамт савласан шаталтын хоолой дотор шатаав. Урвалжийн багана нь 0-1 см кварцын мяндас, 1-7 см кварцын хэлтэрхий, 7-7.5 см кварцын мяндас, 7.5-14 см 0.5 мм-ийн хэт цэвэр Си утас, 14-14.5 см кварцын мяндас, 14.5-16.5 см кварцын хэлтэрхий, 16.5-17 см кварцын мяндас, 17-18.5 см кварцын хэлтэрхий, 18.5-19.5 см кварцын мяндаснаас бүрдсэн. S-ийн изотопын харьцааг Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Дэлхий Ба Хүрээлэн Буй Орчны Шинжлэх Ухааны Сургуулийн Continuous Flow (CF)-EA-IRMS (IsoPrime-EA) багажаар хэмжсэн. Стандарт материал болох IAEA Ag<sub>2</sub>S стандарт S-1-ийг дээжийн хамт дотор хаалтанд хийж, ижил үйл ажиллагааны дагуу шинжлэв. Үр дүнг стандартын шугаман бууралтын аргаар тооцоолсон бөгөөд дээжийн S-ийн изотопын найрлагыг Vienna-Canyon Diablo Troilite (V-CDT) -тай харьцуулан  $\delta$

тэмдэглэгээг ашиглан дараах байдлаар мэдээлэв:

$$\delta^{34}\text{S}(\text{V} - \text{CDT}) = \left[ \frac{(^{34}\text{S}/^{32}\text{S})_{\text{дээж}}}{(^{34}\text{S}/^{32}\text{S})_{\text{стандарт}}} \right] \times 1000$$

Бүх дээж, стандартыг давхардуулан шинжилсэн бөгөөд урт хугацааны шинжилгээнд гаднах нөхөн үйлдвэрлэх чадвар нь  $\pm 0.2$  ‰-ээс илүү байсан.

## ҮР ДҮН

Эрдэнэтийн Овоо Cu-Mo-ны порфир ордоос авсан гол Cu-ийн эрдсүүдэд хэмжсэн Cu-ийн изотопын найрлага ( $\delta^{65}\text{Cu}$ )-ийг Хүснэгт 2-т үзүүлэв. Cu-ийн хүдрийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$  утга нь  $-1.01$  ‰-ээс  $10.0$  ‰-ийн хооронд хэлбэлздэг. Cu (I) сульфидийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$  утга нь дунджаар  $0.82$  ‰, нийт хэлбэлзэл нь  $2.55$  ‰ байна. Малахит, азурит зэрэг Cu (II) эрдсүүд дунджаас

илүү өндөр утгатай байдаг (тус бүр  $6.88$  ‰ ба  $6.29$ ‰), харин хризокolla харьцангуй бага  $\delta^{65}\text{Cu}$   $0.04$  ‰ байна. Халькопиритийн  $\delta^{65}\text{Cu}$  утгууд нь  $0.14$  ‰-ээс  $2.69$  ‰ хооронд хэлбэлздэг бөгөөд дундаж утга нь арай өндөр ( $1.35$  ‰) ба бусад Cu (I) сульфидийн эрдсүүд болох борнит, халькозин, ковеллин зэрэг нь  $0.6$ ‰-ийн ойролцоо бага ба нарийн  $\delta^{65}\text{Cu}$  эгнээнд бөөгнөрдөг (Хүснэгт 2).

Сульфидийн эрдсүүдийн S-ийн изотопын найрлага ( $\delta^{34}\text{S}$ )  $-3.2$  ‰-аас  $1.3$  ‰ хүртэл хэлбэлздэг, дунджаар  $-0.8$  ‰ (Хүснэгт 2). Cu-ийн сульфидийн эрдсүүд нь  $\delta^{34}\text{S}$ -ийн утгаас арай доогуур байгааг харуулж байна: үүнд халькопиритийн хувьд  $-0.5$  ‰, ковеллины хувьд  $-1.1$  ‰, халькозиных  $-1.7$  ‰ ба борнитынх  $-2.0$  ‰, пирит ба молибденитийн дундаж утга нь тус бүр  $0.1$  ‰ ба  $0.5$  ‰ байна.

**Хүснэгт 2. Эрдэнэтийн Овоо Cu-Mo-ны порфир ордын хүдрийн эрдсүүдийн Cu ба S изотопын найрлага. AZ: азурит, BN: борнит, CC: халькозин, CH: хризокolla, CPY: халькопирит, CV: ковеллин, MC: малахит, MB: молибденит, PY: пирит.**

Дээж	Эрдэс	$\delta^{65}\text{Cu}$	2SD	n	$\delta^{34}\text{S}$			Өндөр (м)
					I	II	утга	
ER01	CPY	2.69	0.03	6	0.2	0.2	0.2	1280
ER02	CPY	0.26	0.04	3	-0.3	-0.3	-0.3	1280
ER03	CPY	0.14	0.05	3	-0.4	-0.4	-0.4	1275
ER04	CC	0.77	0.02	3	-1.4	-	-1.4	1352
ER05	CC	0.48	0.05	3	-2.6	-	-2.6	1274
ER06	CH	-1.01	0.01	3	-	-	-	1332
ER07	CH	1.49	0.05	3	-	-	-	1332
ER08	CH	-0.37	0.02	3	-	-	-	1332
ER09	AZ	4.72	0.04	3	-	-	-	1332
ER10	MC	5.76	0.01	3	-	-	-	1332
ER11	CV	0.51	0.06	3	-0.5	-0.1	-0.3	1352
ER12	MC	10.0	0.07	2	-	-	-	1320
ER13	AZ	9.05	0.09	3	-	-	-	1310
ER14	CV+PY	0.21	0.14	2	-2.3	-	-2.3	1250
ER15	BN+PY	0.44	0.02	2	-2.3	-2.4	-2.3	1250

ER16	MB	-	-	-	0.1	0.2	0.2	1250
ER17	BN+PY	0.40	0.06	2	-3.2	-	-3.2	1250
ER18	CV+PY	1.09	0.06	3	-1.0	-1.0	-1.0	1310
ER19	PY	-	-	-	-0.5	-0.4	-0.5	1310
ER20	BN	0.86	0.03	3	-1.1	-1.4	-1.2	1265
ER21	CC	0.88	0.03	2	-2.1	-2.1	-2.1	1265
ER22	CV+PY	0.89	0.08	3	-1.1	-0.8	-1.0	1265
ER23	BN+PY	0.84	0.06	3	-1.9	0.9	-0.5	1265
ER24	PY	-	-	-	-0.4	-	-0.4	1265
ER25	CC+PY	0.63	0.07	2	-0.9	-0.8	-0.8	1280
ER26	BN+PY	0.49	0.09	3	-2.6	-2.3	-2.5	1335
ER27	PY	-	-	-	-2.0	-2.1	-2.0	1335
ER28	CPY	2.32	0.05	3	-1.4	-1.5	-1.4	1310
ER29	MC	5.31	0.03	3	-	-	-	1332
ER30	MC	4.06	0.06	2	-	-	-	1293
ER31	PY	-	-	-	0.4	0.4	0.4	1293
ER32	PY	-	-	-	0.4	0.2	0.3	1274
ER33	PY	-	-	-	-0.1	-0.3	-0.2	1280
ER34	MB	-	-	-	-0.2	-0.1	-0.2	1332
ER35	MB	-	-	-	0.3	0.5	0.4	1332
ER36	MB	-	-	-	0.4	0.5	0.5	1310
ER37	PY	-	-	-	1.3	1.2	1.3	1332
ER38	PY	-	-	-	-0.2	0.0	-0.1	1275
ER39	MB	-	-	-	0.4	0.4	0.4	1275

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### Магмын чулуулаг ба хүдрийн ордуудын $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгууд

Cu-ийн хүдрийн эрдсүүдийн Cu изотопын найрлага 2000-аад оноос хойш тэмдэглэгдэж байгаа бөгөөд  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга хүдрийн ордын төрлөөс хамаарах бөгөөд энэ нь эргээд Cu-ийн гарал үүсэл ба гарал үүслийн процесстой холбоотой юм. Cu нь мантийн эхүүсвэрээс гаралтай гэж үздэг магмын ба гидротермаль ордуудын Cu-ийн сульфидийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$  утга нь мантийн эх үүсвэр  $0.06 \pm 0.20$  ‰ (2SD)-ийн  $\delta^{65}\text{Cu}$  утгатай ойролцоо 0 ‰ орчим хадгалагдан үлддэг, энэ нь Дэлхийн Нийт Силикат (BSE) -ийн  $\delta^{65}\text{Cu}$  утга гэж санал болгосон байна Liu et al. (2015). Порфирийн ордын

гаралтай гипоген Cu-ийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга  $-3.31$ ‰-ээс  $2.28$  ‰ хооронд хэлбэлздэг боловч Зураг 8-т үзүүлсний дагуу ихэвчлэн  $-1$  ‰-ээс  $1$  ‰ хооронд бөөгнөрдөг (Marichal et al., 1999; Larson et al., 2003; Mathur et al., 2009, 2012, 2013, 2018; Li et al., 2010; Mirnejad et al., 2010; Braxton and Mathur, 2011; Palacios et al., 2011; Wu et al., 2017b). Ni-Cu-ЦБМ-ийн ордууд ба вулканоген цул сульфидийн (VMS) ордуудын Cu-ийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга  $-5.26$ ‰-ээс  $3.98$  ‰ хүртэл (Zhu et al., 2000; Larson et al., 2003; Malitch et al., 2014; Ripley et al., 2015; Zhao et al., 2017) ба  $-0.34$ ‰-ээс  $2.97$  ‰-гийн хооронд тус тус хэлбэлзэнэ (Mason et al., 2005; Ikehata et al., 2011). Магмын Cu изотопын найрлагыг судлахын тулд ердийн солир, цэвэр

Cu, магмын чулуулгууд болох боржин, вулканоген чулуулаг, хэт суурилаг болон суурилаг чулуулгийн  $\delta^{65}\text{Cu}$  утгыг хэмжсэн (Luck et al., 2003; Li et al., 2009; Ikehata and Hirata, 2012; Dekov et al., 2013; Liu et al., 2015; Savage et al., 2015; Huang et al., 2016; Baggio et al., 2018). Эдгээр чулуулаг нь ердийн солирт  $-0.51\text{‰}$ -ээс  $0.10\text{‰}$ -ийн хооронд  $\delta^{65}\text{Cu}$ -ийн маш нарийн явцуу утгыг илэрхийлдэг (Luck et al., 2003), цэвэр Cu-нд  $-1.07\text{‰}$ -ээс  $1.18\text{‰}$  -ийн хооронд ((Dekov et al., 2013; Baggio et al., 2018), гранитад  $-0.46\text{‰}$ -ээс  $1.51\text{‰}$ -ийн хооронд (Li et al., 2009), вулканоген чулуулагт  $-0.22\text{‰}$ -ээс  $0.51\text{‰}$  (Liu et al., 2015; Huang et al., 2016) ба хэт суурилаг болон суурилаг чулуулагт  $-0.64\text{‰}$ -ээс  $1.82\text{‰}$ -ийн хооронд (Ikehata and Hirata, 2012; Liu et al., 2015) байна. Ялангуяа, ДГНБ and ДАБ-д  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга нь  $-0.18\text{‰}$ -ээс  $0.21\text{‰}$  хүртэл нарийн эгнээг үүсгэнэ (Liu et al., 2015; Savage et al., 2015; Huang et al., 2016). Метасоматид өртөөгүй перидотитүүд нь ДГНБ and ДАБ-тэй давхцаж,  $-0.15\text{‰}$ -ээс  $0.18\text{‰}$  хооронд хэлбэлздэг (Liu et al., 2015), энэ нь мантийн эх үүсвэртэй нэгэн төрлийн Cu-ийн изотопын найрлагыг илэрхийлдэг.

Магмын процессын явцад мантийн хэсэгчилсэн хайлалт, магмын дифференциаци, өндөр температурын нөхцөл дэх талжилтын фракцжилт зэрэг ялгагдах шинж чанар бүхий Cu изотопын фракцжилт хэд хэдэн судалгаагаар цэвэр магмын чулуулгийн Cu изотоп үүсэх явцад нэгэн төрлийн магмын шинжийг хадгалж байгааг харуулж байна (Li et al., 2009; Ikehata and Hirata, 2012; Huang et al., 2016). Li (2009) нар I-төрлийн гранит ( $0.03 \pm 0.15\text{‰}$ , 2SD) -ийн хувьд  $0\text{‰}$ -ийн ойролцоо


$\delta^{65}\text{Cu}$ -ийн нягт багцлагдсан утгын талаар мэдээлж, Cu-ийн изотопын нэгэн төрлийн мантийн эх үүсвэр ба ялимгүй фракцжилтын процессыг санал болгов. Үүний эсрэгээр S төрлийн гранит нь илүү хувьсах  $\delta^{65}\text{Cu}$  утгыг ( $-0.03 \pm 0.42\text{‰}$ , 2SD) хамарч, тунамал эх үүсвэрүүдийн гетероген Cu изотопын найрлагыг бүрдүүлдэг (Li et al., 2009). Үүнтэй адил нум ба эх газрын базальт ба метасоматитжсан перидотитийн  $\delta^{65}\text{Cu}$  утгын эгнээ нь  $-0.19\text{‰}$ -ээс  $0.47\text{‰}$  ба  $-0.64\text{‰}$  -аас  $1.82\text{‰}$  хооронд тус тус хэлбэлздэг (Liu et al., 2015).  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгын энэхүү илүү өргөн хэлбэлзэл нь исэлдэн ангижрах ба гидротермаль процессын улмаас царцдасын материалыг Cu изотопын нэг төрлийн бус байдалтай холбож өгсөн гэж үзэв (Li et al., 2009; Liu et al., 2015). Тунамал хураагуурын олон янзын Cu изотопын найрлага нь тунамал хурдаст агуулагдсан зэсийн стратиформ хэлбэртэй (SSC) ордын  $\delta^{65}\text{Cu}$   $-3.44\text{‰}$ -ээс  $1.85\text{‰}$  хүртэл хувьсах утгуудад тохиромжтой гэж үздэг (Зураг 8), гэвч бусад нөхцөлд, тухайлбал, исэлдэн ангижрах урвал, Eh ба pH-ийн хэлбэлзэл нь  $\delta^{65}\text{Cu}$  утгыг энэ ордын Cu-ийн эрдсүүдийн төрөлд нөлөөлөлтэй болгож чаддаг (Asael et al., 2007, 2009, 2012; Mathur et al., 2018). Гипоген хүдрийн ордуудын талаархи өмнөх зарим судалгаанууд нь өндөр температурын магмын ба гидротермаль процесуудад ялгаатай  $\delta^{65}\text{Cu}$ -ийн хэлбэлзэл, ялангуяа Cu изотопыг фракцлах процессыг фазын тусгаарлалт эсвэл шингэний буцлах явцад хий, шингэний фазуудад хуваагдсаныг илрүүлжээ (Seo et al., 2007; Li et al., 2010; Maher et al., 2011; Yao et al., 2016; Wu et al., 2017a). Квантын химийн тооцоо (Seo et al.,

2007) ба туршилтын ((Li et al., 2010; Maher et al., 2011) судалгаанууд Cu изотопын фракцлах замын эсрэг заалттай байв. Эхнийх нь илүү хүнд Cu изотопыг хуваахыг санал болгосон ( $^{65}\text{Cu}$ )-ийг хийн фазуудад, тухайлбал  $\text{Cu}_3\text{Cl}_3$ , харин сүүлийнх нь хөнгөн Cu-ийн изотоп ( $^{63}\text{Cu}$ ) нь рН ба давсжилтийн хэлбэлзлийн дор кинетик изотопын фракцжилтын процессоор хянагддаг хийгээр баяжсан болохыг илтгэнэ.

Хүдрийн орддахь Cu-ийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$  утга бага температурын эрдэсжилтийн үйл явцууд ихэвчлэн исэлдэн ангижрах урвалтай холбоотой илүү их хэлбэлзлийг харуулдаг (Зураг 8). Порфирийн ордод, гиперген баяжуулалт ба шүлтгүйжилтийн бүсээс гарсан Cu-ийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн хэлбэлзэл нь  $-16.5\text{‰}$ -аас  $8.30\text{‰}$  хүртэл хэлбэлздэг (Зураг 8), харин гипоген сульфидийн эрдсүүд ихэвчлэн халькопиритийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга нь  $0\text{‰}$ -ийн ойролцоох нарийн явцуу бөөгнөрлийг хамардаг (Maruchal et al., 1999; Larson et al., 2003; Mathur et al., 2009, 2012, 2013, 2018; Li et al., 2010; Mirnejad et al., 2010; Braxton and Mathur, 2011; Palacios et al., 2011; Wu et al., 2017b). Их сульфидтэй Cu-ийн ордын  $\delta^{65}\text{Cu}$ -ийн өгөгдөлд ижил төстэй хэв шинжийг харагдах бөгөөд  $-4.76\text{‰}$ -ээс  $2.84\text{‰}$  (Зураг 8) гэсэн нийт  $\delta^{65}\text{Cu}$ -ийн нийт утгын өргөн хүрээтэй боловч

гипоген гарал үүсэлтэй  $\delta^{65}\text{Cu}$ -ийн ихэнх утгууд нь  $1\text{‰}$  бага хэлбэлзэлтэй байна. (Duan et al., 2016; Wu et al., 2017a). Эдгээр судалгаанууд нь гипоген Cu-ийн  $\delta^{65}\text{Cu}$  шинж порфирийн системтэй адил гиперген орчинд исэлдэн ангижрах нөхцөл өөрчлөгдсөнөөр хувирч байгааг харуулж байна. Далайн ёроолын гидротермаль ордод  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга  $-4.82\text{‰}$ -ээс  $11.5\text{‰}$ -ийн хооронд хэлбэлзсэн өргөн хэлбэлзэл ажиглагдсан (Maruchal et al., 1999; Zhu et al., 2000; Rouxel et al., 2004; Berkenbosch et al., 2015) гол төлөв анхдагч Cu сульфидийн исэлдэлттэй холбоотой гэж үзсэн боловч бусад нарийнтөвөгтэй процессууд, тухайлбал: гидротермаль боловсруулалт, далайн ус ба гидротермал уусмалуудыг хооронд нь холих зэрэг нь Cu изотопын фракцжилтанд чухал үүрэг гүйцэтгэж магадгүй юм (Rouxel et al., 2004). Галт уулын лав (Baggio et al., 2018) ба мантийн чулуулгаас (Ikehata and Hirata, 2012) гаралтай цэвэр Cu-ийнх  $-0.9\text{‰}$ -ээс  $2.9\text{‰}$  ба  $-0.67\text{‰}$ -ээс  $0.14\text{‰}$ -ийн хооронд тус тус хэлбэлздэг (Зураг 8). Аль ч судалгаагаар анхдагч цэвэр Cu нь магмын гарал үүслийн анхны  $\delta^{65}\text{Cu}$  шинжийг хадгалж, хоёрдогч Cu-ийн  $\delta^{65}\text{Cu}$  утгууд нь гидротермаль өөрчлөлтүүд, тухайлбал гиперген нөхцөлд исэлдэлт, шүлтгүйжилт зэргээс шалтгаалан илүү их хэлбэлзэлтэй байдаг.





**Зураг 8.** Энэхүү судалгаанд хамрагдсан орд ба бусад порфирийн Cu орд болон янгу бүрийн Cu-ийн ордын төрлүүдийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгуудын эгнээ (Marichal et al., 1999; Larson et al., 2003; Graham et al., 2004; Mathur et al., 2009, 2010, 2012, 2013; Li et al., 2010; Mirnejad et al., 2010; Braxton and Mathur, 2011; Palacios et al., 2011; Asadi et al., 2015; Wu et al., 2017b), скарн ордууд (Larson et al., 2003; Graham et al., 2004; Maher & Larson, 2007; Wang et al., 2017), их сульфидтай эпитеpmал ордууд (Duan et al., 2016; Wu et al., 2017a), судлын төрлийн ордууд (Jiang et al., 2002; Markl et al., 2006; Haest et al., 2009; Yao et al., 2016), ороген ордууд (Molnabr et al., 2016; Wang et al., 2018), далайн ёроолын гидротермаль хоолойнууд (Marichal et al., 1999; Zhu et al., 2000; Rouxel et al., 2004; Berkenbosch et al., 2015), вулканоген цул сульфидын ордууд (Mason et al., 2005; Ikehata et al., 2011), Ni-Cu-ЦБМ-ын ордууд (Zhu et al., 2000; Larson et al., 2003; Malitch et al., 2014; Ripley et al., 2015; Zhao et al., 2017), SSC ордууд (Asael et al., 2007, 2009, 2012; Li et al., 2010; Mathur et al., 2018), MVT ордууд (Luczaj and Huang, 2018), ба төрөл бүрийн магмын чулуулаг, тухайлбал цэвэр Cu, гранит, вулканоген чулуулаг, мантийн перидотит ба ердийн солир (Luck et al., 2003; Li et al., 2009; Ikehata and Hirata, 2012; Liu et al., 2015; Huang et al., 2016).

Скарн төрлийн ордын  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгын эгнээ нь исэлдэн ангижрах урвал явагдаж байгаатай адил юм. Graham нарын (2004) хийсэн түрүү Cu-ийн изотопын судалгаанд халькопиритийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга өргөн хүрээтэй 1.26 ‰-ээс 13.4‰ хүртэл гэж тэмдэглэгдсэн. Үүний эсрэг хэд хэдэн судалгаагаар халькопирит  $-0.15$  ‰-ээс  $0.77$  ‰ хүртэл харьцангуй нарийн (Wang et al., 2017), халькопирит ба борнит  $-1.29$  ‰-ээс  $3.07$  ‰ хүртэл (Maher and Larson, 2007) харьцангуй нарийн явцуу байгааг тэмдэглэсэн нь скарн системд исэлдэн ангижрах үйл ажиллагаа явагдаж байгааг нотлох баримт юм. Өмнөх судалгаагаар скарн орд дахь гипоген Cu-ийн ердийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн шинжийг үзүүлсэн бөгөөд үүний дараа хэмжсэн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн хэлбэлзэл нь исэлдэн ангижрах урвалаас илүүтэйгээр изотопын бусад фракцжилтын механизмууд, ба эрдэс болон уусмалын хоорондын изотопын фракцжилтын тэнцвэртэй холбоотой гэж үзэв. Карбонатад агуулагдсан Миссисипийн хөндийн төрлийн (MVT) ордын халькопиритийн хязгаарлагдмал  $\delta^{65}\text{Cu}$  утгыг ( $0 \pm 0.5$  ‰) авч (Зураг 8), магмын гаралтай нэгэн төрлийн Cu-ийн эх үүсвэр, исэлдэн ангижрах урвалын бага зэргийн нөлөөлөл,  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгын дараагийн өөрчлөлтийг харуулсан болно (Luczaj and Huang, 2018).

### **Cu изотопын өгөгдөл**

#### **Cu-ийн сульфидийн эрдсүүдийн $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга**

Эрдэнэтийн овооны Cu-Mo порфирийн ордын Cu сульфидийн эрдсүүдэд хэмжсэн  $\delta^{65}\text{Cu}$  утга нь  $0.14$  ‰-ээс  $2.69$  ‰ хооронд хэлбэлзэж байгаа ба Cu-ийн


сульфидийн эрдсүүдийн дундаж  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга бага байгаа (халькопиритийн хувьд  $1.35$  ‰, халькозины хувьд  $0.69$  ‰, борнитийн хувьд  $0.61$  ‰, ковеллины хувьд  $0.68$  ‰) нь Эрдэнэтийн Овоогийн орд дахь Cu-ийн эх үүсвэр нь мантийн гарал үүсэлтэй бөгөөд магмын шинжээ хадгалж байгааг харуулж байна. Халькопиритийн  $\delta^{65}\text{Cu}$  утгууд нь бусад Cu-ийн сульфидийн эрдсүүдтэй харьцуулахад их, зарим талаараа сарнисан харагдаж байна (Зураг 9). Эдгээр хоёр дээжийг эс тооцвол бусад халькопиритийн  $\delta^{65}\text{Cu}$ -ийн дундаж утга нь  $0.20$ ‰ бөгөөд энэ нь BSE-ийнхтэй ойролцоо байна ( $0.06 \pm 0.20$  ‰).

Дээр дурдсанчлан, Maher нарын (2018) хийсэн саяхны судалгаагаар халькозины гарал үүслийг  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгаас хамааран гурван бүлэгт ангилж болно гэж үзсэн. Халькозины  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгууд нь  $-1$  ‰-ээс  $1$  ‰-ийн хооронд хэлбэлздэг бөгөөд тэнцвэрт фракцилалт давамгайлсан өндөр температурын гипоген эрдэсжилтийг илэрхийлнэ. Үүний эсрэгээр тунамал Cu-ийн үе ба гиперген баяжжилтын бүсээс гарсан халькозинууд  $\delta^{65}\text{Cu}$ -ийн  $-1$  ‰-ээс бага ба  $1$  ‰-ээс их утгыг тус тус харуулдаг бөгөөд энэ нь анхдагч Cu-ийн эрдсийн исэлдэн ангижрах урвалаас үүдэлтэй юм. Эдгээр шалгууруудыг үндэслэн Эрдэнэтийн Овоо орд дахь халькозины хэмжсэн  $\delta^{65}\text{Cu}$  утга нь гипоген гарал үүслийг илэрхийлж болно.

Анхдагч ба хоёрдогч эрдсүүдийн хоорондох  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгын ялгаа нь анхдагч Cu-ийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$  утга ба исэлдэн ангижрах урвалын зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг (Larson et al., 2003; Markl et al., 2006; Asael et al., 2007, 2009; Mathur et al., 2009, 2018). Cu-ийн изотопын

найрлагаар гарал үүслийн ангиллыг олон тооны өгөгдлөөр дэмждэг боловч анхдагч ба хоёрдогч халькозины дундаж  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утгын хэмжээ зарим тохиолдолд давхцаж болзошгүй (Mathur et al., 2018),  $\delta^{65}\text{Cu}$ -ийн утга дээр үндэслэн гарал үүслийг тодорхойлоход хөндлөнгөөс оролцож байна. Mathur нар (2009) жишээлбэл Монтана мужийн

Бутте-гээс гаралтай анхдагч (халькозин ба ковеллин) ба хоёрдогч (халькозин) Си-ийн эрдсүүдийг хэмжсэн болно. Эхнийх нь  $\delta^{65}\text{Cu}$ -ийн дундаж утга 0.06 ‰, харин сүүлчийнх нь арай өндөр дундаж  $\delta^{65}\text{Cu}$  (0.40 ‰) байгаа нь гиперген процессын явцад хүнд Си изотопыг бага хэмжээгээр баяжуулж байгааг харуулж байна.



**Зураг 9.** Эрдэнэтийн Овоо ордын Си-ийн хүдрийн эрдсүүдийн  $\delta^{65}\text{Cu}$  утгуудын хистограм

Ойсон гэрлийн микроскопын ажиглалтын үр дүн (Зураг 7) ба эрдсүүдийн хам гарал үүслийн дараалал (Зураг 4) нь Эрдэнэтийн Овоо ордын гиперген баяжилтын орчны хоёрдогч халькозины шинж чанарыг илэрхийлдэг. Халькозин нь ихэвчлэн пирит ба халькопирит дээр хучсан эсвэл ууссан хэлбэрээр тохиолддог

(Зураг 7Б–Д). Макро ажиглалтаар нь халькозин нь массив хэлбэрээр бус харин бусад сульфидийн мөхлөгийг голчлон бүрхсэн байдалтай харагдана. Ковеллин ба борнитын мөхлөгүүд нь халькозины мөхлөг болон бусад сульфидийн мөхлөгүүдийг түрснээр үүсдэг. Тиймээс Эрдэнэтийн Овоо ордын ихэнх судалгаанд Си-ийн

